

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

Санамж:

1. Асуулт даалгавар бүрийг дуустал, анхааралтай уншиж гүйцэтгээрэй.
2. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой.

1. Тодорхой хил хязгаар бүхий нутаг дэвсгэр, хуулийн ерөнхий тогтолцоо, үндэсний ялгарал бүхий хүмүүсийн нэгдлийг онолын ямар ойлголтоор илэрхийлдэг вэ? \1 оноо\
A. Нийгэм
B. Иргэншил
C. Соёл
D. Нийгмийн дэвшил
E. Улс үндэстэн
2. Аль нь зөв бэ? \1 оноо\
A. Нийгэм бол хэл үнэлэмж, хэм хэмжээ зэргийг эхлэл болгодог тогтолцоо мөн
B. Нийгэм бол хүмүүсийн харилцан үйлдэл мөн
C. Нийгэм бол ард түмний бүлэг, үүнд тодорхой нутаг дэвсгэрт амьдарч, улс төрийн засаглалын нэг тогтолцооны албат нь байж, өөрийгөө хүрээлж буй бусад бүлгээс танигдан ялгардаг тийм бүлэг юм
D. Хариулт бүгд буруу
E. Хариулт бүгд зөв
3. Нийгмийг шугаман бус тогтолцооны буюу синергетикийн онолоор тодорхойлсон ойлголт аль нь вэ? \1 оноо\
A. Нийгэм нь нягт хэлхээ холбоонд оршдог элементүүдийн нийтлэг тогтолцоо
B. Нийгэм нь нийлмэл тогтолцоо бус, харин бүхэллэг тогтолцоо
C. Нийгэм нь хүн төрөлхтний чин хүслэнгийн биежилт
D. Нийгэм нь бие хүмүүс, тэдгээрийн хоорондын социаль харилцааны цогц
E. Нийгэм дэх үйл явц, үзэгдэл нь эмх цэгцтэйн сацуу бас аяндаа өөрөө цэгцрэх үйл явцаар журамлагдан хөгждөг
4. “Нийгмийн амьдралын хүрээ” гэсэн ойлголтод илүүц зүйл дурдсан бол аль нь вэ? \1 оноо\
A. Соёл – олон нийтийн хүрээ
B. Соёл – оюун санааны хүрээ
C. Улс төрийн хүрээ
D. Эдийн засгийн хүрээ
E. Социаль хүрээ
5. Хүмүүсийг нийгэмшүүлэх ба суурь үнэт зүйл, дадлага, практикт суралцуулах нь нийгмийн институтын чиг үүрэг байдаг. \1 оноо\
A. Боловсролын
B. Эрх зүйн
C. Эдийн засгийн
D. Улс төрийн
E. Тохирох хариулт алга
6. Хувь хүний эрхийг хэрэгжүүлэх баталгаа болж, төрийн үйл ажиллагааг хяналтандаа байлгадаг нийгмийн байгууллагуудын цогцыг ямар ойлголтоор илэрхийлдэг вэ? \1 оноо\
A. Хүн
B. Хувь хүн
C. Төр
D. Иргэний нийгэм
E. Хаалттай нийгэм
7. Нийгмийн институтуудын шууд хамаарагдах харилцаануудад буруу холбоос орсон бол аль нь вэ? \1 оноо\
A. Гэр бүлийн институт - эцэг, эх, хүүхэд - бөгж, зүүлт, гэрээ
B. Эдийн засгийн институт - ажил олгогч, хөлсний ажилчин - мөнгөн тэмдэгтүүд, худалдаа
C. Улс төрийн институт - хууль тогтоомж, эрх зүйн субъект - зар суртчилгаа, дээд сургууль
D. Шашны институт - хамба, гэсгүй - загалмай, судар
E. Боловсролын институт - багш, шавь - үнэмлэх, диплом, цол
8. Үндсэн бус институтыг юу гэж нэрлэдэг вэ? \1 оноо\
A. Нийгмийн институц
B. Нийгэм
C. Нийгмийн үүрэг
D. Нийгмийн систем
E. Нийгмийн практик

9. Нийгмийн хэв маягуудаас аж үйлдвэржсэн нийгэмд хамааралгүйг олно уу \3 оноо\
- A. Үйлдвэрлэл, олон төрөл эрчим хүч ашиглах болсон
 B. Нийгмийн тэгш байдлыг зохицуулахад анхаарах болсон
 C. Зах зээлийн эдийн засгийн харилцаа хөгжиж, нэг ижил бүтээгдэхүүнийг их хэмжээгээр үйлдвэрлэх болсон
 D. Оюуны хөдөлмөрт тулгуурлаж, анги давхрааны ялгаа гүнзгийрсэн
 E. Хүн амын олонх нь хотууд болон үндэсний төр улсад суурьшсан
10. “Үхэр урт чацтай, адуу урт чацтай, тэмээ урт чацтай байдаг бөгөөд эдгээр нь бод мал болдог тул ер нь бод мал урт чацтай хэмээж болно” гэхэд аль аргад илүү түшиглэх вэ? \3 оноо\
- A. Дедукци
 B. Индукци
 C. Анализ
 D. Синтез
 E. Аль нь ч биш
11. Нийт нийгэмд хамаарахуйц тухайлбал, хүний амьдралын нөхцөл, чанар дээшлэх гэх зэрэг томоохон хэмжээний эерэг үр дагавруудын дүнг юу гэж нэрлэж болох вэ? \1 оноо\
- A. Нийгмийн үйл явц
 B. Нийгмийн үзэгдэл
 C. Нийгмийн хөдөлгөөн
 D. Нийгмийн дэвшил
 E. Нийгмийн шинэчлэл
12. Аль нь төрөлх статус вэ? \3 оноо\
- A. Миний аав онц тээвэрчин хүн
 B. Би Дорноговь аймгийн дунд сургууль төгссөн
 C. Миний өвөө боржигон овогтой
 D. Манай охин, хүү МУИС төгссөн
 E. Би боловсролын тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнагдсан
13. Эцэг, эх, эмээ, өвөө, ач, зээ, авга, нагац, үеэл ах дүү зэргээс бүрдсэн гэр бүлийг тодорхойлно уу? \3 оноо\
- A. Эгалитар гэр бүл
 B. Өргөжсөн гэр бүл
 C. Нийлмэл гэр бүл
 D. Нуклеар (энгийн) гэр бүл
 E. Өрөөсгөл гэр бүл
14. “Улс төр бол нийгэм дэх үнэт зүйлсийг эрх мэдэлд тулгуурлан хуваарилан байршуулах үйл байдал” гэж хэн тодорхойлсон бэ? \1 оноо\
- A. Аристотель
 B. Д.Истон
 C. Ф.Бро
 D. Н.Макиавелли
 E. Х.Лассуэл
15. Аль бодомж нь буруу вэ? \1 оноо\
- A. Засаглалын эзлэхүүн нь хичнээн тооны засаглал хэн нэгний буюу ямар нэгэн байгууллагын гарт төвлөрч байгааг харуулдаг
 B. Засаглалын цаг хугацаа нь тухайн засаглалын оршин тогтнох хугацаа
 C. Засаглалын орон зай нь тодорхой хэмжээтэй газар нутагт засаглалын үйл ажиллагаа үр ашигтай явагдана гэсэн үг
 D. Засаглалын бүтцийн бүрдэлд засаглалын газар нутаг зэрэг орно
 E. Засаглалын хэмжээ нь ямар нэгэн засгийн нөлөө, ач холбогдол, цар хүрээ, хэм хэмжээг тодорхойлох үзүүлэлт
16. Эрх мэдлийн хэлбэрүүдэд өгөгдсөн жишээг зөв харгалзуулна уу? \1оноо\
1. Албадлагын хүч хэрэглэх
 2. Наймаалцах
 3. Үүрэг үүсгэх
- A. Иргэн татвар төлж, төр үйлчилгээ үзүүлэх
 B. Иргэн татвараа заавал төлөх
 C. Иргэн татвараа төлөхгүй байх
- A. 1A2C3B
 B. 1B2A3C
 C. 1C2A3B
 D. 1C2B3A
 E. 1B2C3A
17. Монголын эзэнт гүрний үед засаглалын ямар легитим шинжийн хэв маяг ноёрхож байсан бэ? \1оноо\
- A. Харизмат легитим шинж
 B. Уламжлалт легитим шинж
 C. Хууль ёсны легитим шинж
 D. А ба В хариулт зөв
 E. Аль нь ч легитим шинжид хамаарахгүй

18. Улс төрийн тогтолцооны дэд бүтцэд аль нь орох вэ? \1 оноо\
- A. Тогтолцооны дэд тогтолцоо B. Хэм хэмжээ – зохицуулалтын дэд тогтолцоо
C. Мэдээлэл–харилцааны дэд тогтолцоо D. Дээрх бүгд зөв E. Бүгд буруу
19. Нийгмийн улс төрийн тогтолцооны цөм болдог улс төрийн байгууллага аль нь вэ? \1 оноо\
- A. Улс төрийн нам B. Төр C. Улсын Их Хурал
D. Үндсэн хуулийн цэц E. Иргэний нийгмийн байгууллага
20. Төрийн бус байгууллага гэж юу вэ? \1 оноо\
- A. Ашгийн төлөөх, өөрийгөө удирдах зарчмаар ажилладаг олон нийтийн байгууллага
B. Төрөөс хараат бус, хувийн ашгийн төлөө бус, өөрийгөө удирдах зарчмаар үйл ажиллагаа явуулдаг байгууллага
C. Төрөөс хараат бус, ашгийн төлөөх байгууллага
D. Төрөөс хараат, ашгийн бус байгууллага
E. Төрөөс хараат, өөрийгөө удирдах зарчмаар үйл ажиллагаа явуулдаг байгууллага
21. Төр, засаглалын эх сурвалжийг бурханы зарлиг, элчийн үйл ажиллагааны бодит биелэл гэж үздэг шашны онолын төлөөлөгчид аль нь вэ? \1 оноо\
- A. Г.Гроций, В.Спинзо, Ж.Локк B. Е. Дюринг, Л.Гумплович, К.Каутский
C. К.Маркс, Ф.Энгельс, В.И.Ленин D. Конфуций, Аристотель, Р.Фильмер
E. С.Августин, Фома Аквинский
22. Төрийн шинж нь төр улс үүсэх, орших үндэс төдийгүй тухайн улсын нутаг дэвсгэр дээр оршин суугаа захирах, захирагдах харилцаанд орших гол субъект юм. \2 оноо\
- A. Нутаг дэвсгэр B. Эрх мэдэл C. Хүн ам D. Засаглал E. Орон зай
23. Төрийн эрх мэдлийг хуваарилах Ш.Монтескьегийн онол нь аль вэ? \1 оноо\
- A. Хуулийг хэрэгжүүлэх, хуулийг хянах, хууль сахиулах
B. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх C. Хууль тогтоох, хууль сахиулах, шүүх
D. Хууль тогтоох, шүүх, прокурор E. Хууль боловсруулах, гүйцэтгэх, шүүх
24. Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэх бүрэн эрхэд хамаарахгүй нь аль вэ? \3 оноо\
- A. Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах
B. Нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх
C. Төрийн захиргааны төв байгууллагыг шуурхай удирдах
D. Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих
E. Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах
25. Төрийн хэлбэр гэсэн ойлголтод үл хамаарахыг олно уу? \2 оноо\
- A. Төрийн засаглалын хэлбэр B. Төрийн дэглэм
C. Төрийн байгууламжийн хэлбэр D. Түүхэн уламжлалт дэглэм
E. Зөв хариулт байхгүй
26. Улс төрийн намуудын сонгуульд авсан саналын тоотой хувь тэнцүүлэн парламентын суудлыг намуудад хуваарилах нь: \1 оноо\
- A. Мажоритар тогтолцоо B. Пропорциональ тогтолцоо
C. Дийлэнх олонхийн тогтолцоо D. Холимог тогтолцоо E. Аль нь ч биш
27. Монгол улсын Төрийн эрх барих дээд байгууллага нь: \2 оноо\
- A. Монгол Улсын ерөнхийлөгч B. Монгол Улсын Их Хурал
C. Монгол Улсын Засгийн Газар D. Улсын дээд шүүх
E. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц

28. Эдийн засгийн үйл ажиллагаа гэж юу вэ? \1 оноо\
- A. Үйлдвэрлэл, хуваарилалт, арилжаа, хэрэглээ гэсэн дарааллаар явагддаг амьд орчил бүхий хөдөлгөөн
 B. Хүний хязгаарлагдмал хэрэгцээг хангахад чиглэсэн үйл ажиллагаа
 C. Улсын үндэсний баялаг, газар, капитал, ажиллах хүч болон тэдгээрийн нэгдмэл цогц байдал
 D. Макро эдийн засгийн эс болсон нэгжүүд, тэдгээрт явагдах эдийн засгийн үзэгдэл
 E. Үндэсний эдийн засагт бүтээгдсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний мөнгөөр илэрийлэгдсэн дүн
29. Эрэлтийн хууль гэдэг нь: \1 оноо\
- A. Эрэлтэнд хэрэглэгчийн тоо нөлөөлөх
 B. Эрэлтэнд хэрэглэгчийн орлого нөлөөлөх
 C. Эрэлтэнд тухайн барааны үнэ нөлөөлөх
 D. Эрэлтэнд хослох барааны үнэ нөлөөлөх
 E. Эрэлтэнд оруулах барааны үнэ нөлөөлөх
30. Дараах тохиолдлуудын алинд нь бараа, үйлчилгээний хомсдол үүсдэг вэ? \1 оноо\
- A. Эрэлт > нийлүүлэлт
 B. Эрэлт < нийлүүлэлт
 C. Эрэлт = нийлүүлэлт
 D. А ба В хариулт зөв
 E. Аль нь биш
31. Баатарт нэг төгрөг, Баярмаад хоёр ширхэг 50 мөнгө /металл зоос/ байв. Инфляцийн үед энэ хоёрын хэн нь баян бэ? \2 оноо\
- A. Энэ хоёр инфляцид яг адилхан хэмжээгээр өртөнө
 B. Яг адилхан нэг л төгрөг шүү дээ
 C. Баатар цаасан нэг төгрөгтэй учир баян
 D. Баярмаа үнээсээ их өртөгтэй мөнгөтэй учир баян
 E. Ийм асуулт байх нь ач холбогдолгүй
32. Монгол улсад дараах өгөгдсөн онуудад эдийн засгийн ямар тогтолцоотой байсныг зөв холбож тэмдэглэнэ үү? \2 оноо\
1. 1974 онд
 2. 2013 онд
 3. 1889 онд
- A. Уламжлалт эдийн засгийн тогтолцоо
 B. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоо
 C. Зах зээлийн эдийн засгийн тогтолцоо
- A. 1A, 2B, 3C
 B. 1B, 2A, 3C
 C. 1B, 2C, 3A
 D. 1C, 2A, 3B
 E. 1C, 2B, 3A
33. “Төрийн зохицуулалтаар эдийн засгийн үр өгөөжийг хангах болно” гэсэн зарчмын шинэ санааг “Ажил эрхлэлт, хүү мөнгөний ерөнхий онол” бүтээлдээ үндэслэсэн онолч хэн нь вэ? \1 оноо\
- A. А.Маршалл
 B. Адам.Смит
 C. М.Кейнс
 D. А.М. Фридман
 E. К.Маркс
34. Инфляци үүсдэг шалтгаануудыг тоочихдоо буруу зүйл хамааруулсан бол аль нь вэ? \2 оноо\
- A. Бараа үйлчилгээний хомсдолтой байдал
 B. Улс оронд байгалийн гамшиг учирсан
 C. Цалинг нэмэхдээ бүтээгдэхүүн ба үйлчилгээний өсөлттэй нь зөв уялдуулаагүй
 D. Мөнгөн гүйлгээний бодлого алдагдаж, банк буруу тооцсоны улмаас гүйлгээнд хэт их мөнгө орсон
 E. Бүгд зөв
35. Төгс өрсөлдөөний ач холбогдлыг тодорхойлно уу? \2 оноо\
- A. Хэрэглэгчдийн сонголт өргөн болно
 B. Чанартай бараа үйлчилгээгээр хангагдана
 C. Үйлдвэрлэлд шинэ техник технологи нэвтэрнэ
 D. Үнэ буурна
 E. Бүгд зөв
36. Аль нь ажилгүйдлийг бууруулах эдийн засгийн арга замд хамаарахгүй вэ? \2 оноо\
- A. Ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг урамшуулан дэмжих
 B. Цалин, хөдөлмөрийн үнэ цэнийг нэмэгдүүлэх
 C. Хөдөлмөрийн биржийн албыг бэхжүүлэх
 D. Хөдөлмөрийн багтаамж ихтэй жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих
 E. Импортыг орлуулах бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг дэмжих

37. Татварын тогтолцоог илэрхийлэх жишээнд илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? \2 оноо\
- A. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар В. Рашаан ус ашигласны төлбөр
C. Хөрөнгийн даатгал D.Тэмдэгтийн хураамж E. Аль нь ч биш
38. Нийгмийн бүлгүүдийн тэгш бус байдлыг төрийн хуулиар тогтоож өгдөг давхраажлын хэв маяг аль нь вэ? \1 оноо\
- A. Каст В. Боолчлол C. Язгуур D. Анги E. Аль нь ч биш
39. Малчны хүү Ц.Элбэгдорж сэтгүүлч мэргэжил эзэмшиж, сэтгүүлчээр ажиллаж байгаад Улсын Их Хурлын гишүүн болж, улмаар Монгол Улсын Ерөнхийлөгч болсон. Энэ нь нийгмийн шилжих хөдөлгөөний ямар төрлийн жишээ вэ? \2 оноо\
- A. Үе хоорондын В. Үе доторх C. Бүтцийн
D. Гэр бүлийн E. Нутаг дэвсгэрийн
40. Улс орон үйлдвэржиж, эдийн засгийн бүтэц боловсронгуй болох явцыг дагаж гардаг шилжих хөдөлгөөнийг гэнэ. \1 оноо\
- A. Байр суурь үл өөрчлөгдөх шилжилт В. Бүтцийн шилжих хөдөлгөөн
C. Нийгмийн шилжих хөдөлгөөн D. Газар зүйн шилжих хөдөлгөөн
E. Үе хоорондын шилжих хөдөлгөөн
41. Аль нь нийгмийн давхраажлын хэмжигдэхүүн бэ? \1 оноо\
- A. Эд баялаг В. Нэр хүнд C. Эрх мэдэл
D. А,В,С хариулт зөв E. Аль нь ч биш
42. Нийгмийн хамгаалал хэнд чиглэгдэж байх ёстой вэ? \1 оноо\
- A. Ажилгүйчүүдэд В. Нийгмийн эмзэг хэсгийнхэнд
C. Нийгмийн элит хэсгийнхэнд D. Нийгмийн бүх гишүүдэд
E. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд
43. Багш Даш нь боловсролын байгууллагад 28 жил ажилласан бөгөөд 2014 онд 60 нас хүрчээ. Энэ тохиолдолд багш Даш нь нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу *нийгмийн даатгалын аль төрлийн сангаас* сар бүр тэтгэвэр авах эрх үүсэх вэ? \2 оноо\
- A. Ажилгүйдлийн даатгалын сангаас В. Эрүүл мэндийн даатгалын сангаас
C. Тэтгэмжийн даатгалын сангаас D. Тэтгэврийн даатгалын сангаас
E. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас
44. Хүн юмуу гэр бүл хоол хүнс, хувцас, сууцтай байхад хүрэлцэхүйц орлого гэж Засгийн газраас тогтоосон албан ёсны мөнгөний хэмжээ аль нь вэ? \1 оноо\
- A. Ядуурлын хэмжээ В. Харьцангуй ядуурал C. Үнэмлэхүй ядуурал
D. Ядуурлын босго E. Аль нь ч биш
45. Орчин үеийн боолчлолын хэлбэр аль нь вэ? \1 оноо\
- A. Хүчинд автан гэрлэх В. Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр
C. Хүний наймаа D. Бэлгийн боолчлол E. Дээрх бүгд
46. Аль бодомж нь зөв бэ? \1 оноо\
- A. Соёл бол байгаль, нийгмийн үзэгдэл
B. Соёл бол нийгмийн тогтонги ба өөрчлөмтгий шинжтэй үзэгдэл
C. Соёл бол нийгэмд хааяа тохиолдох ховор үзэгдэл
D. Соёл бол байгальд илрэх байдлын эсрэг үзэгдэл
E. Бүгд буруу

47. Хүннүгийн хаад өглөө наранд, үдэш саранд мөргөдөг байжээ. Энэ өгөгдөл алинд нь хамаарах вэ? \1 оноо\
- A. Монгол хэл
C. Монголын бэлгэдэл
B. Монголчуудын шашин шүтлэг
D. Монгол ёс суртахуун
E. Монгол ухаан
48. Нийгмийн тогтвортой байдал, дэг журмыг хадгалах хөшүүргийг юу гэж нэрлэдэг вэ? \1 оноо\
- A. Хариуцлага
D. Дүрэм, журам
B. Сахилга
E. Нийгмийн хяналт
C. Хэм хэмжээ
49. Соёлын өөрчлөлтөд үл хамаарах зүйл аль нь вэ? \1 оноо\
- A. Соёлын нэвтрэлт
D. Нээлт
B. Соёлын статик
E. Холимог хэл
C. Шинэ бүтээл
50. “Урлаг бол урлагийн төлөө байх ёстой” гэсэн уриа *соёлын аль хэлбэрийг* илэрхийлж байна вэ? \1 оноо\
- A. Үндэсний соёл
D. Элит соёл
B. Ардын соёл
E. Нийгмийн соёл
C. Дагуул соёл
51. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу? \3 оноо\
- | | |
|------------------|---|
| 1. Үнэлэмж | A. Юу үнэн бөгөөд яг ноттой болох тухай санаа |
| 2. Хэм хэмжээ | B. Нийгмийн харилцааг тохируулагч хэрэгсэл |
| 3. Итгэл үнэмшил | C. Сайн ба муу, сайхан ба муухай |
- A. 1C,2 B,3A B. 1C,2 A,3B C. 1A,2B,3C D. 1A,2C,3A E. 1B,2 A,3C
52. Аль нь олон улсын *эдийн засгийн харилцааны хэлбэрийг* илэрхийлж байна вэ? \1 оноо\
- A. Бараа үйлчилгээг улс үндэстэн, бүс нутгийн хилээр дамжуулан солилцох
B. Улс орнуудын хооронд гэрээ хилэлцээр байгуулах, элч төлөөлөгч солилцох
C. Гадаад улс орны эрдэмтэд, судлаачид шинжлэх ухааны тодорхой асуудлаар хамтран судалгаа хийх
D. Гадаад орнуудад Монголын соёлын өдрүүдийг зохион байгуулах
E. Төрийн тэргүүний айлчлал хийх
53. Олон улсын хэмжээнд боловсрол, шинжлэх ухаан, соёлын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилготой НҮБ-ын төрөлжсөн байгууллага аль нь вэ? \1 оноо\
- A. ЮНИДО B. ЮНЕСКО C. ЮНИСЕФ D. ОУВС E. ДЭМБ
54. Японы “Ниссан” компани олон улсын харилцааны аль субъектэд хамаарах вэ? \2 оноо\
- A. Олон улсын байгууллага
D. Ард түмэн
B. Төр
E. Алинд нь ч хамаарахгүй
C. Үндэстэн дамнасан байгууллага
55. Манай улс хүүхдийн эрхийн конвенцид хэдэн онд элсэн орсон бэ? \1 оноо\
- A. 1989 B. 1990 C. 1946 D. 1992 E. 1949
56. Монгол улсын үндсэн хуульд заасан иргэн бүрийн үндсэн үүргийг дурьдахдаа түүнд үл хамаарах зүйл оруулсан бол аль нь вэ? \1 оноо\
- A. Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэн сахин биелүүлэх
B. Хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх
C. Хуулиар ногдуулсан албан татвар төлөх
D. Эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах
E. Ажил мэргэшлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцлөөр хангуулах

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж:

1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг бөглөөрэй.
2. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноо

2.1 Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу?

/5 оноо/

a	Агнуурын болон түүвэрлэгчдийн нийгэм	1	Үйлдвэрлэлийн удирдлага, зохион байгуулалтад шинжлэх ухааны мэдлэгийг өргөн ашиглаж, дулааны эрчим хүчийг цахилгааны болон атомын эрчим хүчээр сольсон
b	Цэцэрлэгийн аж ахуйн буюу энгийн тариалангийн нийгэм	2	Эртний Египетэд үүссэн, малыг ажиллах хүч болгон ашигласан. Энэ нийгмийн суурин дээр төр үүсэж, бичиг үсэг зохиогдон мөнгөн гүйлгээ бий болж, худалдаа өргөжсөн
c	Газар тариалан (хөдөө аж ахуй)-гийн нийгэм	3	МТӨ 4000 жилийн тэртээ Дундад Дорнодод үүссэн. Энэ нийгмийн бүтэц нь нарийн харилцаа бүхий ураг төрлийн холбоо байсан
d	Аж үйлдвэржсэн нийгэм	4	XX зууны сүүлийн 25 жилд үүссэн. Шинжлэх ухаан, боловсролын үйлчилгээ хөгжиж, их сургуулиуд тэргүүлэх үүргийг гүйцэтгэдэг
e	Аж үйлдвэржсэний дараах нийгэм	5	Ан агнаж, хүнсний ургамал, жимс жимсгэнэ түүн амьдарч байсан ба нийгмийн амьдралын зохион байгуулалт нь ураг төрлийн холбоонд тулгуурлана.

2.2 Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу?

/5 оноо/

a	Сонирхолын бүлэг	1	Өөрийн гэсэн тодорхой зорилго, чиглэл дээр үндэслэгдсэн учир улс төрийн зорилгыг агуулсан, төрийн дотоод гадаад бодлого, үйл ажиллагаанд нөлөө үзүүлэгч
b	Аномик (хууль бус буюу хууль үгүй) бүлэг	2	Хүмүүс голдуу яс үндэс, угсаа гарал, арьс өнгө, зан заншил, хэл, шашин шүтлэг, нас хүйс, нийгмийн байдал зэрэг нийтлэгээрээ ялгаатай
c	Эвлэл холбооны бус бүлэг	3	Цэрэг зэвсэглэл, арми, сүм хийд зэрэг субъектын шууд удирдлага дор зохион байгуулалттай үүсгэн байгуулагддаг
d	Байгууллагажсан бүлэг	4	Улс төрийн байгууллагаас өөрсөддөө илүү ашигтай, тохиромжтой шийдвэр гаргуулах, нийтлэг ашиг сонирхлын үндсэн дээр нэгдсэн хүмүүсийн үйл ажиллагаа
e	Эвлэл холбооны бүлэг	5	Тодорхой зохион байгуулалтгүй хэсэг, бөөн хүмүүсийн цугларалт, бослого үймээн

2.3 Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу?

/5 оноо/

a	Шууд татвар	1	Тухайн татвар ямар нэгэн шат дамжлагыг дамжих замаар гүйцэтгэсэн ажил үйлчилгээ бараа бүтээгдэхүүний борлуулалттай уялдуулсан татвар
b	Шууд бус татвар	2	Аливаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ямар нэгэн шат дамжлагагүйгээр орлогынх нь хэмжээтэй уялдуулан тогтоосон татвар
c	Өсгөн нэмэгдүүлэх татвар (прогрессив)	3	Орлого өсөхөд татварын дундаж хувь буурах
d	Хувь тэнцүүлсэн татвар (пропорциональ)	4	Орлогын бүх түвшин татварын хувь адил
e	Өсгөн бууруулах татвар (регрессив)	5	Орлого өсөхийн хэрээр татварын дундаж хувь өсдөг

2.4 Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу?

/5 оноо/

a	Ядуурлын босго	1	Албан ёсоор тогтоосон ядуурлын зааг юмуу босгон дотор амьдарч байгаа хүн амын эзлэх хувь
b	Үнэмлэхүй ядуурал	2	Амьдралын боломжийн жишиг гэж тухайн нийгмийн үзэж байгаа хэрэгцээг хангах чадваргүй байдал
c	Ядуурлын хэмжээ, коэффициент	3	Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, олон хүүхэдтэй өрх толгойлсон эхчүүд зэрэг ядууралд бусдаас илүү өртөх хандлагатай хүмүүс
d	Харьцангуй ядуурал	4	Хувь хүн юмуу гэр бүл хүнс, хувцас, сууцтай байхад хүрэлцэх доод орлого гэж албан ёсоор тогтоосон мөнгөний хэмжээ юм
e	Нийгмийн эмзэг бүлэг	5	Амьдралын наад захын хэрэгцээгээ хангаж чадах чадваргүй байдал